

БОГИНО ХУГАЦААНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ (С-4-5)

ОЛГОХ ХҮРЭЭ:

Түр хугацааны үзүүлбэр(Урлагийн үйл ажиллагаа гэх мэт), Зар сурталчилгаа-Загвар өмсөх, Лекц-Илтгэл тавих*, Судалгаа шинжилгээ хийх, Технологи зааж сургах, Ажил үйлчилгээ нийлүүлэх зэрэг ашгийн зорилгоор богино хугацааны хөдөлмөр эрхлэх иргэн

ø Ашиг олох гэрээний дагуу БНСУ-ын төрийн болон хувийн байгууллагаас уригдаж богино хугацаагаар лекц, илтгэл тавих тохиолдолд

ø Үзэсгэлэнд оролцон уран бүтээлээ худалдаж ашиг олох зураач, уран барималч гэх мэт уран бүтээлчид

ø Улирлын хөдөлмөр эрхлэх богино хугацааны (С-4-1~4) визний хувьд “Виз авах зөвшөөрлийн код” мэдүүлэх шаардлагатай.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуй нэгжийн захирал: Байгууллагын татварын тодорхойлолт, аж ахуйн нэгжийн гэрчилгээ
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, Нийгмийн даатгалын лавлагаа, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад : Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга хураангуй хэлбэрээр (Хамтран эзэмшигч байх боломжгүй)
4. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа
5. Урилга (Урих болсон шалтгаан, Эх орондоо буцаж ирэхийг батлан дааж буй агуулгыг тусгах)
6. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар, Хуулийн этгээдийн гэрчилгээний лавлагаа гэх мэт
7. Хөдөлмөрийн гэрээ болон зохион байгуулагч талаас арга хэмжээнд оролцохыг тодорхойлсон бичиг баримт
8. Холбогдох засаг захиргааны байгууллагын даргын ажилд авахыг санал болгосон тодорхойлолт эсхүл албан бичиг, ажилд авах зайлшгүй шаардлагыг нотлох бичиг баримт
 - Уран бүтээлчийн хувьд БНСУ-ын Медиа контент үнэлгээний хорооны санал болгосон тодорхойлолт
 - Мэргэжлийн хөл бөмбөг буюу тамирчин, ахлагч, шүүгчийн хувьд БНСУ-ын хөл бөмбөгийн хорооны санал болгосон тодорхойлолт
 - Мэргэжлийн Го даамны тамирчингийн хувьд БНСУ-ын Го даамны холбооны санал болгосон тодорхойлолт
 - Дэвшилтэт технологи эзэмшсэн буюу(Gold болон IT карт) эзэмших нөхцөл хангасан боловсон хүчний хувьд БНСУ-ын Аж үйлдвэр, технологийн сан болон БНСУ-ын IT Venture компани, Жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооны санал болгосон тодорхойлолт
 - Гадаадын мэргэжлийн боловсон хүчний хувьд жижиг дунд бизнесийн корпорацаас санал болгосон тодорхойлолтыг ажил байдлыг нотлох бичиг баримтын оронд бүрдүүлж өгөх боломжтой

ø БНСУ-д зорчих зорилгын дагуу нэмэлт бичиг баримт шаардах боломжтой.